

Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 он

## АГУУЛГА

<b>НЭГ:</b> Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө.....	2
<b>ХОЁР:</b> Нэгжийн дотоод үйл ажиллагаа.....	3
<b>ГУРАВ:</b> Бичиг хэрэг, хүний нөөцийн чиглэлээр.....	8
<b>ДӨРӨВ:</b> Сургалт, сурталчилгааны чиглэлээр.....	9
<b>ТАВ:</b> Хяналт шалгалтын чиглэлээр.....	13
<b>ЗУРГАА:</b> Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр.....	16
<b>ДОЛОО:</b> Эд хөрөнгийн эрхийн улсыг бүртгэлийн чиглэлээр.....	20
<b>НАЙМ:</b> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр.....	22
<b>ЕС:</b> Санхүү бүртгэлийн чиглэлээр .....	25
<b>АРАВ:</b> Мэдээлэл технологийн чиглэлээр .....	25

## **СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021.12.02

Баруун-Урт хот

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд, холбогдох тогтоол шийдвэр, журмуудын хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 28 ажилтан албан хаагчидтайгаар бүртгэлийн үйлчилгээг аймгийн 63.4 мянган иргэнд хүргэж байна. Тус хэлтэс нь аймгийн Нутгийн удирдлагын ордны шинээр баригдсан 2 дугаар байрны 8 давхарт 10 өрөө бүхий 200 мкв талбайтай байранд нүүн орж бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын "Улсын бүртгэлийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал"-д тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг ханган 2021 онд зохион байгуулсан үйл ажиллагаагаа тайлагнаж байна. Үүнд:

### **НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг "Аргачлал загвар батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу төлөвлөгөөний төслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, 2000 тэмдэгтэд багтаан товч тодорхой, бодитой, үг үсгийн алдааг хянан тогтоосон хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж батлуулсан. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 дэд зорилго, 8 зорилт, 41 арга хэмжээний хүрээнд боловсруулан төлөвлөгөөг 2021 оны 12 сарын 02-ны байдлаар хэрэгжилтийг 98.3 хувьтай хэрэгжүүлж ажиллалаа. Хугацаа болоогүй хэрэгжиж байгаа 90 хувийн гүйцэтгэлтэй 9 ажил үйлчилгээ байгаа болно.

Хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс тасаг нэгжүүд, цаашлаад тасаг нэгжээс улсын бүртгэгч нартай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргатай байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.

Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Борхүү нь Аймгийн Засаг даргатай байгууллагын 2021 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан

аймгийн удирдлагуудад зохих мэдээ, мэдээллийг тухай бүр гарган өгч, санхүүгийн хувьд шаардлагатай зарим зардлыг шийдвэрлүүлэн хамтран ажиллаж байна.

### ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг дарга, Тамгын газрын дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нар тус хэлтсийн албан хаагчидтай 2020 онд уулзалт зохион байгуулж, ажлын байрны нөхцөл байдалтай танилцсан. Тухайн үед алба хаагчдын ажиллах, ард иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Нутгийн удирдлагын 2 дугаар байр болох 16 давхар байр шинээр ашиглалтанд орсонтой холбогдуудан тус хэлтэст 8-н давхрын 200 мкв талбай бүхий 10 өрөөг шийдвэрлэн 2021 оны 04 сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн. Шинэ байранд нүүж орох бэлтгэл ажлын хүрээнд сүлжээний хэвийн ажиллагаа, тохижилт, архивын өрөөний бэлтгэл ажил зэрэг төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Ажлын байрны хаяг, албан хаагчдын албан тушаал, нэрийг Монгол бичиг болон криллээр бичиж байршуулсан.



Улсын бүртгэлийн хэлтсээс нийт ажилтан албан хаагчиддаа цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаа дэмжих бүтээгдэхүүн, маск, спирт, салимон, бээлий, нүүрний циллодон хаалт зэргийг тухай бүр өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.

Төрийн захиргааны 22 албан хаагчдын 2021 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогийн мэдүүлгийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан баталгааны маягыг албажуулан авсан. Мөн тайлант онд шинээр томилогдсон болон хүүхэд асрах чөлөөтэй байж байгаад ажилдаа орох хүсэлт гаргасан албан хаагчдаас хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогийн мэдүүлгийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан баталгааны маягыг албажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус хэлтсийн төрийн төрийн захиргааны 22, төрийн үйлчилгээний 4, гэрээт 2 албан хаагч, 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 15 дугаар тойргийн хэсгийн хороодод ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн 69 ажилтнаас төрийн болон албаны нууц задруулахгүй байх нууцын баталгааг гаргуулан авч хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах асуудлаар Сүхбаатар аймаг дахь Тагнуулын хэлтэстэй ажил хэргийн уулзалт зохион байгуулж тогтмол хамтран ажиллаж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын дунд зохион байгуулагдах ирц бүртгэлийн программын дадлага ажлын сургалтыг зохион байгуулсан. Итгэмжлэгдсэн ажилтнуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагын хамгаалалттай Улсын бүртгэлийн ерөнхий газраас татан авч сургалттай өдрүүдэд танхимыг хамгаалалтанд авч хамтран ажилласан бөгөөд сонгуулийн дараа Цагдаа, Тагнуулийн байгууллагын хамгаалалттай бүрэн бүтэн буцаан хүргэж өгсөн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр 2021 оны сар бүрийн 25-ны өдрийг “Залуучуудыг дэмжих өдөр” болгон зарласантай холбогдуулан хэлтсийн даргын 2021 оны 03-р сарын 24- ны өдрийн А/04 тоот тушаалаар байгууллагын Залуучуудын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан зөвлөлийн даргаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Б.Одонзул гишүүдэд Иргэний улсын бүртгэгч Б.Алтанзул, мэдээлэл технологийн инженер А.Одбаяр нар ажиллаж байна. Залуучуудын зөвлөл нь 2021 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу биелэлтийг ханган ажиллаж байгаа болно.

Хэлтсийн дотоод ажлын зохион байгуулалтын үйл явцын хүрээнд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комисс, Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу тодорхой хугацаанд албан хаагчдын ажлын цагийг богиногосон хэлбэрт шилжүүлэн ажилласан. Ингэснээрээ цар тахлын хүнд үед бага насны хүүхдүүдээ хараа хяналтгүй орхих явдал багассан.

Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа.

Ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх хүнс тээврийн жолоочийг бусадтай хавьтал болохоос сэргийлж гэрийн ажиглалтанд хяналттайгаар оруулах зорилгоор аймгийн Шуурхай штабын хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу төрийн байгууллагаас 3 албан хаагчийг постонд гаргах ажилд оролцон тус хэлтсийн 3 албан хаагч 2021.02.04-ны өдрөөс эхлэн 14 хоногт 1 удаа постонд гарч ачаа тээврийн машины жолооч нарт хяналт тавин ажилласан.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хөнгөвчлөх зорилгоор хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний буланг ажиллуулж байна. Уг үйлчилгээг хэлтсийн угтах үйлчилгээний ажилтан хариуцан ажиллаж байгаа бөгөөд Нэг цэгийн үйлчилгээ E-Mongolia, Opendata-аар дамжуулан эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 176 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 36 лавлагаа, лавлагааг тус тус гарган бүртгэл хөтлөн иргэдэд лавлагаа мэдээллийн үйлчилгээг үзүүлсэн байна.



Угтах үйлчилгээний ажилтан нь иргэдэд бүртгэлийн үйлчилгээг ойртуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэх, чиглүүлэх, давхар албан хаагчдын цаг бүртгэлийг хянаж гадуур ажлын дэвтэр хөтлөх зэрэг ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу албан хаагчдын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хянаж, холбогдох хууль тогтоомж, журам, албан тушаалын тодорхойлолтонд заасан ажил үүргийг баримтлан ажиллаж буй эсэхэд хяналт тавих, үнэлгээний дүнг нэгтгэн үр дүнг танилцуулах үүрэг бүхий “Байгууллагын үнэлгээний баг”-ийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.

2020 онд Улсын бүртгэлтийн байгууллага үүсч хөгжсөний түүх 80 жилийн ойн хүрээнд Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид өөрсдийн хүч хөдөлмөрөөр 80 ширхэг мод суулган УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС-ийн төгөл бүтээн байгуулж байсан бөгөөд энэхүү төглийн ургаагүй мод бутад нөхөн сэргээлт хийсэн ба нэмэлтээр 50 ширхэг модыг хамт олноороо тарьж, услах, цэвэрлэх, тордох ажлуудыг зохион байгуулж байна. Тайлант онд нийт 120 ширхэгийг ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь “Хог хаягдлын тухай” хууль, Хүн амын эрүүл мэнд, хотын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор хуваарьт газар болох Хүүхдийн тоглоомын талбайн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэлээ.




2021 оны сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг Улсын бүртгэлийн байгууллагын 81 жилийн ойг тохиолдуулан 3 бүртгэлийн чиглэлээр зохион байгуулж иргэдэд бүртгэлийн үйлчилгээ явуулж, тараах материал олгож ажилласан.

Иргэдийн санал хүсэлт, бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилготой 70512673 дугаар утсанд нийт 260 иргэн холбогдож иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн үйлчилгээ архивын лавлагааг үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тус тус хүргэж шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна.

Аймгийн 2021-2025 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2021 оны зорилтот тусгасан бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс судлан Киоск машин суурилуулах ажлыг Гэрэгэ ХХК-тай гэрээ компанитай гэрээ байгуулан аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 3500000 төгрөгийн үнэ бүхий киоск машин худалдан авч, үйлчилгээний зааланд байрлуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Киоск машин байрлуулсанаар Иргэний улсын бүртгэлийн-26, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн – 34, Хуулийн этгээдийн – 11 төрлийн үйлчилгээ, 18 төрлийн лавлагааны тэмдэгтийн хураамжийг төвлөрүүлэн иргэдэд шуурхай үйлчилж байна.

“Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг.



БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сумын улсын бүртгэгч нарт компьютер, принтер, канон, скайнер, хурууны хээ уншигч, зургийн аппарат зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн. Төрийн үйлчилгээг ард, иргэдэд түргэн шуурхай хүргэн Сүхбаатар аймаг дахь улсын бүртгэлийн ажилчид ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2021 онд шинэ байранд нүүж орсонтой холбогдуулан мэдээллийн самбаруудын нэг стандартаар шинэчилсэн загварын дагуу хийлгэн байршуулж, хэлтсийн үйл ажиллагаа, төсөв санхүү, мэдээ мэдээллийн нээлттэй ил тод байдлыг

ханган хэрэглэгчдэд хүргэхийг зорилго болгон 4 төрлийн самбарт мэдээллийг тогтмол цаг үеийн асуудлаар шинэчлэн байршуулан ажиллаж байна.

Мөн мэдээллийн самбар тус бүрт иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах саналын хайрцагийг байршуулан болно. Самбар тус бүр дээр цахим хаяг, вэб сайт, утасны дугаар, мэйл зэргийг хэвлэн иргэдийг цахимаар үйлчлүүлэх нөхцөл бололцоог хангасан.



Хэлтсийн 2021 оны төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Аудитын дүгнэлт, шилэн дансны мэдээ, бүтэц орон тоо, төсвийн төсөөлөл, санхүүгийн тайлан зэргийг санхүүгийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор байршуулдаг. Мөн авилга ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж бүртгэлийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилготой үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байгаа ба холбогдох төлөвлөгөө, тайлан, зөвлөмж, сурталчилгааг байрлуулан ажиллаж байна.

2021 оны жилийн байдлаар тус хэлтэст нийт 24 өргөдөл бүртгэгдсэн байна. Төрлөөр нь авч үзвэл ажлын байр албан хаагчидтай холбоотой 18, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой 1, хуулийн этгээдтэй холбоотой 5 өргөдлийг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж мэдээг УБЕГ-т хүргүүлсэн. Нийт 24 өргөдлийг 100 хувь үнэн зөв гарган шийдвэрлэсэн.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд хэлтсийн 26 албан хаагчийг вакциний 1, 2-р тунд бүрэн хамруулсан. 2 албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас вакцинд хамрагдаагүй.

2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр төвийн нийт 15 албан хаагчийг түргэвчилсэн шинжилгээнд бүрэн хамруулсан. 2021 оны 11 сарын 16-ны өдөр аймгийн нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж, нийт 28 албан хаагчийн урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан.

УБЕГ-т шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн талаар судалгааг танилцуулан УБЕГ-ын актлагдсан ширээ, үйлчигээний сандал, сейф, архивын 2 ширхэг тавиур зэргийг татан авч албан байршуулан ажилласан.

Хүний амьдралын аз жаргал, баяр баясгалантай мөчүүдийг нэг бол гэрлэлтээ батлуулах мөч байдаг. Гэрлэлтээ бүртгүүлж буй бүх хосууддаа дурсамж үлдээх зорилгоор Халзан сум "Гэрлэх ёслол"-ын булантай боллоо.





## ГУРАВ. БИЧИГ ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

2021 оны жилийн эцсийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас тус хэлтсийн хүний нөөцтэй холбоотой 10 тушаал, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 12 тушаал гарсан.

Мөн дээд газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 20 чиглэл, албан даалгавар 3, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тогтоол 1, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд баримтлах Ковид-9 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам 2 ирж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Хэлтсийн даргын боловсон хүчинтэй холбоотой 15 үндсэн үйл ажиллагаатай холбоотой 7 тушаалыг шийдвэрийн төсөлд санал авах хяналтын дагалдах хуудсаар баталгаажуулан албажуулан гаргасан.

Хэлтсийн хэмжээнд нийт 24 өргөдөл, хүсэлт бүртгэгдсэн. Үүнд: хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 5, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 1, албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт 18 тус тус хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Нийт өргөдөлийн шийдвэрлэлт 100 хувь. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн хэмжээнд нийт цаасаар 85, цахим хаяг буюу [sukhbaatar@burtgel.gov.mn](mailto:sukhbaatar@burtgel.gov.mn) хаягаар 227 гаруй албан бичиг хүлээн авсан. Нийт 312 бичигнээс хариу хүргүүлэх шаардлагатай 119 бичгэнд хугацаанд хариу хүргүүлж шийдвэрлэлтийн байдал 100 хувь.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/705 тоот тушаалаар баталсан Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, Хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаанда мөрдлөг болгон ажиллаж байна. Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно.

2021 оны жилийн эцсийн байдлаар даргын зөвлөлийн хурлыг 3 удаа хуралдаж тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.

Аймгийн удирдах ажилтны хурлаас гарсан шийдвэрийг танилцуулах хурлыг 7 хоног бүрийн мягмар гарагт зохион байгуулж нийт 7 удаа танхимаар сумдын улсын бүртгэгч нартай цахимаар холбогдож тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.

Ахмад настны хуулийн дагуу тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан Ц.Буд, З.Ичинхорлоо нарт Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын зүгээс тус бүр 50000 төгрөгийн тэтгэмж олгосон.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд хэлтсийн 27 албан хаагчийг вакциний 1 ба 2,3 тун бүрэн хамруулсан. 3 албан хаагч нь эрүүл мэндийн шалтгааны улмаас вакцинд хамрагдаагүй байна.

2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр төвийн нийт 15 албан хаагчийг түргэвчилсэн шинжилгээнд бүрэн хамруулсан.

Тус хэлтсийн Онгон сумын улсын бүртгэгч нь 2021 оны 04 дүгээр сард хүнд өвчний улмаас нас барсан тул түүний гэр бүлд нь хэлтсийн албан хаагчдын зүгээс 1350000 төгрөг, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 300000 нийт 1650000 төгрөгийн нэг удаагийн тусламжийг үзүүлсэн.

Эрдэнэнцагаан, Мөнххаан сумдын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэл хийх сургалтад цахимаар хамрагдсан. Эрдэнэнцагаан сумын улсын бүртгэгч Ц.Содцэцэг, Мөнххаан сумын улсын бүртгэгч Т.Отгонцэцэг нар эд хөрөнгийн эрхийн бүртгэл хийх шалгалт өгч тэнцсэн. Суманд эд хөрөнгийн бүртгэл хийх ажил эхлээгүй байгаа ба бэлтгэл ажил хангагдаж байна.

2021 оны 06 сарын 07 өдөр ХААН даатгал компанийн мэргэжилтэн сургалт хийж, Эд хөрөнгийн ахлах болон 2 бүртгэгч даатгалд хамрагдсан. Гэрээний заалтууд 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг 14 заалтын хүрээнд боловсруулан хэлтсийн даргаар батлуулсан бөгөөд Ковид-19 цар тахлын улмаас танхимын бус онлайн сургалтанд албан хаагчдыг хамруулж байна. Жилийн эцсийн байдлаар УБЕГазар болон аймаг орон нутаг, бусад байгууллагаас онлайнаар зохион байгуулагдсан 36 сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.

УБЕГ-аас 2021 оны байдлаар иргэн, эд хөрөнгө хуулийн этгээд архив, бичиг хэргийн чиглэлээр цахимаар зохион байгуулагдсан 28 сургалтад давхардсан тоогоор 140 албан хаагч сургалтад хамрагдсан. Сургалтад хамрагдсаны үр дүнд албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн.

Sukhbaatar.burtgel.gov.mn сайтын “Хэрэглэгч” танд булангийн “Нээлттэй ажлын байрны зар” хэсэгт Онгон, эрдэнэнцагаан, уулбаян сумдын улсын бүртгэгчийн ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлаж, зарыг байршууллаа.

Тайлант онд 3 албан хаагч УБЕГ-т очиж төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн.

Байгууллагын зүгээс албан хаагчдад үзүүлэх үүднээс бага насны нэг хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгож байна.

### **ДӨРӨВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Нээлттэй хаалганы өдөрлөгийг Улсын бүртгэлийн байгууллагын 81 жилийн ойг тохиолдуулан 3 бүртгэлийн чиглэлээр зохион байгуулан ажиллалаа. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаагаа дамжуулан иргэдэд Улсын бүртгэлийн багц хуулийг сурталчилахаас гадна, гол гарч буй зөрчлүүдийн талаар мэдээлэл өгч, бүртгэл тус бүрээр гарын авлага тараах материалыг тархааж ажилласан. Мөн e-mongolia –г хэрхэн ашиглах талаар сурталчилгааны ажлуудыг хийсэн. Өдөрлөгөөр 246 гарын авлага тараах материал иргэнд олгож, 76 бүртгэлийг хийсэн.

2021 онд Улсын бүртгэлийн Ерөнхий газар хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл хэлтсийн дотоод үйл ажиллагааны мэдээ мэдээлийг [www.sukhbaatar.burtgel.gov.mn](http://www.sukhbaatar.burtgel.gov.mn) цахим болон [www.facebook.com/suburtgel](https://www.facebook.com/suburtgel) фэйсбүүк хуудсанд 280 удаа байршуулсан.

2021 оны байдлаар УБЕГ болон орон нутгийн байгууллагуудаас танхимын болон онлайнаар 34 сургалт зохион байгуулагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:

1. Аймаг дүүргийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч улсын бүртгэгчийг чадавхжуулах, бүртгэл хөтлөх цахим системийн боловсруулалтанд анхаарах асуудал сэдэвт сургалт 2021.03.17
2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгөх сургалт 2021.03.31
3. Монгол Улсын Ерөнхийлөчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанг хууль эрх зүйн мэдээллээр хангах тэдгээртэй гэрээ байгуулахад анхаарах асуудлаар харъя нэгжийн удирдлагуудад чиглэл, зөвлөмж өгөх сургалт 2021.05.10
4. Орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулахад анхаарах асуудал, чиглэл өгөх сургалт 2020.05.31
5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 21 аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт 2021.06.17
6. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газартай хамтран Төрийн албаны тухай хууль, архив бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт сэдэвт арга зүйн сургалт 2021.06.15
7. 2021.06.25-нд УБЕГ-аас “Хөдөлмөрлөх эрхийн үндсэн асуудал “ сургалт
8. 2021.08.21.22-нд УБЕГ-т “ it инженер нарын сургалт” танхим
9. 2021.08.24-нд УБЕГ-аас “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах “
- 10.2021.09.10-нд УБЕГ-аас “Бодлого төлөвлөлт, дотоод үйл ажиллагааны хангах”
- 11.2021.10.14-нд УБЕГ-аас “Гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх” сургалт
- 12.2021.10.20-нд УБЕГ-аас “ Галын аюулгүй байдлыг хангахад зориулсан”
- 13.2021.08.30-нд УБЕГ-аас танхимын сургалт
- 14.2021.10.28-нд УБЕГ-аас “Төсөл хэрэгжилт”
- 15.2021.11.16-нд УБЕГ-аас “Хүний нөөцийн “ сургалт
- 16.2021.11.10-нд УБЕГ-аас “Ахмад настны хөгжил, хамгааллын үндсэн хөтөлбөр”
- 17.2021.11.19-нд УБЕГ-аас “бичиг хэргийн ажилтнуудад”

Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд:



- 18.Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй “Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ” сэдэвт богино хугацааны зайн сургалт 2021.01.27
- 19.Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмыг танилцуулах цахим сургалт 2021.01.28

20. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт: Алсын хараа 2050" сэдэвт зайн сургалт 2021.02.22-2021.03.05
21. Агентлаг, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нар, ХШҮ хариуцсан мэргэжилтэн, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нар зориулсан сургалт Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санаачлагаар MERIT төслийн дэмжлэгтэй хүргэж буй “ҮР ДҮНД СУУРИЛСАН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” сэдэвт цахим сургалт 2021.04.05 уг сургалтанд хэлтсийн төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 22 албан хаагч бүрэн хамрагдаж СЕРТИФИКАТТАЙ төгссөн.
22. Аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга, албан хаагчид, Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудын дарга, ЭБАТ нарт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд зохион “Авлигын эсрэг цахим сургалт 2021.05.07
23. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1 дэх заалтын хүрээнд аймгийн хэмжээнд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем EPR системийг нэвтрүүлж байгаатай холбоотойгоор системийн ашиглалтын талаар танхимын сургалт, сургалтанд хэлтсийн дарга, мэдээлэл технологийн ажилтан, бичиг хэргий ажилтан нарт 2021.05.11
24. Нийслэл, 21 аймгийн 330 сумдын төрийн албаны эмэгтэй албан хаагчид оролцоно. Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөр”-ийн цахим сургалт 2021.05.18
25. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн газрын хэлтсээс Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан нарт “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, цахим сургалт 2021.06.03
26. 2021.10.22-нд АХШҮГ-аас “ Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ”
27. 2021.11.19-нд АЗДГ-аас “Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс”
28. 2021. 11.18-нд АТГ-аас “Авлигын эсрэг цахим сургалт”
29. 2021.10.19-нд АЕГ-аас “Архив албан хэрэг хөтлөлийн сургалт”
30. 2021.11.17-нд АЗДТГ-аас “Архив албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн журам”
31. 201.10.28-нд Төрийн албаны зөвлөлөөс “ Албан хаагчийн зөөлөн үр чадвар хөгжүүлэх”
32. 2021.09.21-нд ТЕГ-аас “ Төрийн болон албан нууц”
33. 2021.10.15-нд АТГ-аас “Авлигын эсрэг сургалт”

Дотооддоо сургалт зохион байгуулсан байдал:

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар Сүхбаатар аймгийн 13 сумдын улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарт цахим сургалтыг тус тус зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллав.

Уг сургалтуудаар ТЕГ-ын Сүхбаатар аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан, хошууч Б.Баярсайхан НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ /үүрэг, хариуцлага/ талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу ажилтнуудад хувиарлан бэлтгэл ажлыг хангаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн удирдамжийн дагуу “Сонгуулийн ирц бүртгэлийн программ”-ын сургалтыг УБЕГ-ын Тамгын газрын дарга Г.Цолмон даргаар ахлуулсан сургалтын багийн бүрэлдэхүүнтэй тусгай хөтөлбөр боловсруулан хамтран тус тус зохион байгуулж ажилласан.

Сургалт эхлэхээс 2 цагийн өмнө сургалтын танхимыг ариутган сургалтын өдрүүдэд сургалтад оролцож буй нийт албан хаагчид буюу итгэмжлэгдсэн ажилтнуудад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын 1 болон 2 дугаар тундаа бүрэн хамрагдсан байх шаардлагыг тавьж амны хаалт заавал зүүсэн байх, гараа халдваргүйжүүлж байх, биеийн халууныг хэмжүүлэх зэрэгт онцгой анхаарч, танхимд идэх зүйл, ундаа, шингэн зүйлийг оруулах, тоног төхөөрөмжийн ойролцоо тавихыг хатуу хориглох зэрэг зөвлөмжийг өгч халууныг нь үзэж, халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.



## ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч Ц.Алтанцэцэг нь 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Тайлант хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, журам, дүрэм, заавруудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж иргэний улсын бүртгэлийн нийт 7986 бүртгэлд хяналт тавьж ажиллаа.

### Иргэний бүртгэлийн чиглэлээр:

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан ажлыг хийж гүйцэтгэсэн. Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд нийт 2985 бүртгэлээс 98 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан байна.

### Хяналтын байцаагчийн дүгнэлтээр:

1. Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай -18
2. Бүртгэл хүчингүй болгох-21
3. Зөрчил арилгах тухай -29
4. Бүртгэлд засвар өөрчлөлт хийх тухай-15
5. Регистрийн дугаар хүчингүй болгох тухай-3

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан ажлын хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөн, сонгогчийн шилжилт хөдөлгөөний нийт 1254 бүртгэлд хяналт тавьж ажилласан байна.

Хяналт шалгалтын газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийг хүртэлх улсын бүртгэл түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянаж шалгахад

илэрсэн зөрчлийг улсын байцаагчийн албан шаардлагын дагуу арилгаж ажиллаа. Иргэний улсын бүртгэлийн 26 зөрчлийг арилгуулан тайланг ХШГ-т хүргүүлсэн болно.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн 896 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллаа. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/589 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын явцад 2021 оны 01 дүгээр сарын 04-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хугацаанд бүртгэсэн худалдах худалдан гэрээний үнийн дүнгээр үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнг өөрчлөөгүй гэх зөрчлийг нэг бүрчлэн шалгаж, холбогдох эх нотлох баримтыг дүгнэж үзэхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд хавсралтад дурдсан бүртгэлийн 416 худалдах худалдан авах гэрээний бүртгэлд бүртгэх үед үнийн дүнгээр үл хөдлөх хөрөнгийн үнэ өөрчлөөгүй зөрүүтэй, дутуу бүртгэсэн, болох нь тогтоогдсон тул 416 бүртгэлийн зөрчлийг арилгуулах зорилгоор 2021 оны 09 дугаар сарын 20-ний өдөр 5196 дугаар нэмэлт өөрчлөлт оруулах тухай дүгнэлт гаргасан болно. Хяналт тавьсан бүртгэлээс илэрсэн зөрчлийг хяналтын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилган ажиллаа.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан зөрчил нь:

1. Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох-21
2. Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай -65
3. Хувийн хэргийн буцаалт хийх тухай 5

Хяналт шалгалтын газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийг хүртэлх улсын бүртгэл түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмд нийцсэн эсэхийг хянаж шалгахад илэрсэн зөрчлийг улсын байцаагчийн албан шаардлагын дагуу арилгаж ажиллаа. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 3 зөрчлийг арилгуулан тайланг ХШГ-т хүргүүлсэн болно.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар 112 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллаа. Хяналт шалгалтаар 9 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан байна.

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллалаа.

Санхүүгийн чиглэлээр:

2021 оны 11 сарын байдлаар хэлтсийн шилэн дансны хөтлөлт, 1-11 сарын санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, үнэт цаасны тайлан гаргалт нэгтгэлийг хянан шалгалт хийж ажиллалаа. Зөрчил багассан байна гэж үзэж байна.

#### Архивын улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 356 бүртгэлд хяналт тавьж ажиллаа. Мөн байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаагааг хэлтсийн 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 202 нэр төрлийн баримт бичгийг устгасан.

#### Торгууль, шийтгэвэр:

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн, үндэсний энгийн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх үрэгдүүлсэн, гэмтээсэн, иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, ашиглах, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн, иргэн хуулийн этгээд тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д “улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2, 6, 7 , 10.20 дугаар зүйлийн 1, 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 15.23 дугаар зүйлийн 1.1, 15.24 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргаж зөрчсөн 212 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэн төсөвт нийт 7660 000 төгрөг оруулсан байна. Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 50 хувь буурсан үзүүлэлттэй байна. Хуулийн дагуу хоёр зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэсэн болно

Мөн Өргөдөл гомдлын шийдвэрлэлт мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 12 өргөдөл ирсэн байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -8
- Эд хөрөнгийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -9
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -1
- Хяналт шалгалтын ажлын тайлан, тоон мэдээг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны статистик мэдээг сар бүрийн Хэлтсийн даргад болон Хяналт шалгалтын газарт, хялбаршуулан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн шийтгэл оногдуулсан тухай мэдээг Хяналт шалгалтын газар, Прокурорын газарт, хэлтсийн нягтлан бодогчид, Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг Тамгын газарт, Үнэт цаасны мэдээг санхүүд тус тус хуулийн хугацаанд бүрэн хүргүүлж, ажиллаж байсан. Сүүлд



Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны статистик мэдээг сар бүрийн Хэлтсийн даргад болон Хяналт шалгалтын газарт, хялбаршуулан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн шийтгэл оногдуулсан тухай мэдээг Хяналт шалгалтын газар, Прокурорын газарт, хэлтсийн нягтлан бодогчид хүргүүлж байгаа бөгөөд Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг Тамгын газарт, Үнэт цаасны мэдээг УБЕГ-газарт хүргүүлэхгүй орон нутгийн нягтлан, нярав нарт гаргаж өгч байна.

- Зөрчлийн тухай судалгаа мэдээ тайланг Хэлтсийн даргад болон аймгийн прокурорын газрын хяналтын прокурорт тухай бүр гаргаж танилцуулж ажилласан.

#### Сургалтад хамрагдсан байдал:

УБЕГ -аас зохион байгуулсан: 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” цахим сургалтад амжилттай оролцож гэрчилгээ гардан авсан.

Мөн Монголын Хуульчдын Холбооноос зохион байгуулсан 4 удаагийн цахим сургалтад хамрагдаж Хуульчийн кредит нөхөн авсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт зохион байгуулсан 6 цахим сургалт болон Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан Хяналтын байцаагч нарын эрх зүйн 2 өдрийн сургалтад хамрагдсан болно.

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг нийтэд сурталчлах зорилгоор 8700 гаруй иргэн хуулийн этгээдэд холбогдох улсын бүртгэлийн талаар хуульд заасан журмын дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үүнд: Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн талаар болон Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, түүнийг таслан зогсоох, Зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх талаар 6 удаа сургалт зохион байгуулсан, олон нийтэд орон нутгийн телевиз, радиогоор 3 удаа, улсын бүртгэлийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн талаар танин мэдүүлсэн, мэдээлэл хүргэсэн байна.

### **ЗУРГАА. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСАГ**

#### **1. Иргэний бүртгэлийн чиглэлээр**

Иргэний бүртгэлийн тасаг нь 2021 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 6643 бүртгэл, 8151 лавлагааг иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллагад олгон ажилласан. Тайлант онд иргэний бүртгэлийн [www.civil.mn](http://www.civil.mn) ситем хэрэглээнд нэвтэрч, хэрэглээний явцад гарч буй хүндрэл бэрхшээл, асуудлыг тухай бүр УБЕГ-ын мэдээлэл технологийн газар, интерактив ХХК-ны систем хариуцсан ажилтануудтай холбогдон, санал хүргүүлж ажиллаа.

2021 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн жилтэй холбогдуулан УБЕГ-аас баталсан “Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу төлөвлөсөн ажлуудаа хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлэлээ. Төлөвлөгөөний дагуу аймгийн 13 сумдын ИТХ-ын хэсэг байгуулсан тухай тогтоолыг хүлээн авч, [election.gazag.mn](http://election.gazag.mn) системд хэсгийн мэдээлэл, нутаг, дэвсгэр, санал авах байрны мэдээллийг оруулж хуулийн хугацаанд бүртгэлээ.

Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг эхний байдлаар хэвлэх эрхийг Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар дээр нээж, 01-65 дугаар бүхий нийт 65 хэсгийн 41729 сонгогчдын нэрийн жагсаалтыг 2021.05.28-ны өдөр хэсэг тус бүрээр 2 хувь хэвлэж, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд, 1 хувийг 13 сумдын 65 хэсгийн хороодод хэлтсээс томилогдсон ажлын хэсэг тус тус хүргэн өгсөн.

Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад зориулсан эрх зүйн сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 12-н өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтаар иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгогч шилжих журам, итгэмжлэгдсэн ажилтаны чиг үүргийн талаар тус тус мэдээлэл хийсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24 дугаар зүйлд заасны дагуу “Сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 14-өөс доошгүй хонгийн өмнө сонгогч шилжих хүсэлтийг хүлээн авна” гэж заасны дагуу аймгийн хэмжээнд нийт 537 лавлагаа сүлжээнд бүртгэгдсэн. Үүнээс сонгогч шилжин явсан 259, сонгогч шилжин ирсэн 257, нас баралт 14, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 361 тус тус нэрсийн жагсаалтад тусгагдсан.

Лавлагаа тусгагдсан байдлаарх сонгогчийн нэрсийн жагсаалтад сонгуулийн насны иргэдийн тоо эцсийн байдлаар 41098 иргэн бүртгэгдсэн.

Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлуудын талаарх илтгэх хуудасыг тухай бүр УБЕГ-т тайлагнан, Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах өдөр аймгийн хэмжээнд дэх нийт хэсгүүдийн ирц бүртгэлийн мэдээг нэгтгэн [n.enkhmaa@burtgel.gov.mn](mailto:n.enkhmaa@burtgel.gov.mn) хаягаар УБЕГ-т хүргүүлж ажиллаа. Аймгийн хэмжээнд сонгуулийн ирц 64,76 хувьтай явагдсан байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад [j.narantuya@burtgel.gov.mn](mailto:j.narantuya@burtgel.gov.mn) хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Т.Байгальмаад [t.baigalmaa@burtgel.gov.mn](mailto:t.baigalmaa@burtgel.gov.mn) хаягаар мөн Иргэний бүртгэлийн тасгийн сар бүрийн тайланг [p.enkhnar@burtgel.gov.mn](mailto:p.enkhnar@burtgel.gov.mn) хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Хагас жилийн хүрээнд иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг тоон мэдээгээр аймгийн хэмжээнд нэгтгэвэл:

- ✚ төрсний бүртгэлд 1345 хүүхэд бүртгүүлснээс 680 нь эрэгтэй, 665 нь эмэгтэй,
- ✚ гэрлэлтийн бүртгэл 318
- ✚ гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 26 бүртгэгдсэнээс захирааны журмаар 3, шүүхийн журмаар 23
- ✚ Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 29
- ✚ Эцэг тогтоолтын бүртгэл 40
- ✚ Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 36
- ✚ Нас барсны бүртгэл 330




- ✚ 16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан бүртгэл 686
- ✚ Иргэний үнэмлэхний дахин олголт 81
- ✚ Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1254
- ✚ Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 167
- ✚ БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 0
- ✚ БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 0
- ✚ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 473
- ✚ Регистрийн дугаарын өөчлөлтийн бүртгэл 8
- ✚ Аймаг доторх шилжилт хөдөлгөөн 1671

Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг нэгтгэвэл :

- ✚ Албан хэрэгцээнд 5430
- ✚ Хууль хяналтын байгууллагад 280
- ✚ Иргэнд 2441
- ✚ Төрийн болон төрийн бусад байгууллагад өгсөн лавлагаа 0

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд иргэний бүртгэлийн тасгаас албан хаагчдын боловсрол, мэргэжил, ур чадварыг сайжруулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 13 сумын улсын бүртгэгч нарыг 3 баг болгон хувиарлаж, багийн ахлагчийг томилон өгөгдсөн сэдвийн хүрээнд мэдээлэл бэлтгэн оролцлоо.

Баг тус бүр багаар хамтран ажиллаж өгөгдсөн сэдвийн хүрээнд хууль тогтоомж, ойлголт тодорхойлолт, статистик үзүүлэлт, дэлхийн бусад улс орны бүртгэлийн онцлог, анхаарах асуудал, бүртгэл хийхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл зэргийг дурьдан мэдээлэл хийж тулгамдсан асуудлын талаар харилцан ярилцсан.



### Сэдвийн хувиарлалтыг товч танилцуулвал:

- 1 дүгээр баг – Төрөлт, Нас баралтын бүртгэл
- 2 дугаар баг - Эцэг тогтоолт, гэрлэлтийн бүртгэл
- 3 дугаар баг – Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл, үрчлэлтийн бүртгэл

Дээрх сэдвийн хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн долоо хоног бүрийн баасан гариг бүрт цахимаар зохион байгуулсан ба энэхүү арга хэмцээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хамтын ажиллагаа сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Өнөртуяа, Иргэний улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Д.Янжинжаргал, Т.Энхбаатар нар оролцож, мэдээлэл солилцон арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.


Цахим үнэмлэхний сунгалт, шинээр цахим үнэмлэх авах иргэд хуулийн хугацаанд ирж сунгалтаа хийлгэхгүй байгаа учир Хүн ам, өрхийн

280422222	ХӨӨӨӨӨ	ГАЛЭГЭЭЭЭ	БҮГДЭЭЭЭ	Дэлгэр	9911864	Замхан
280422223	ХӨӨӨӨ	ВАТЭЭЭ	МӨНӨӨӨӨ	Эвэн	9911865	Замхан
280422224	ЖААЭЭЭЭ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911866	Замхан
280422225	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911867	Замхан
280422226	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911868	Замхан
280422227	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911869	Замхан
280422228	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911870	Замхан
280422229	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911871	Замхан
280422230	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911872	Замхан
280422231	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911873	Замхан
280422232	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911874	Замхан
280422233	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911875	Замхан
280422234	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911876	Замхан
280422235	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911877	Замхан
280422236	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911878	Замхан
280422237	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911879	Замхан
280422238	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911880	Замхан
280422239	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911881	Замхан
280422240	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911882	Замхан
280422241	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911883	Замхан
280422242	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911884	Замхан
280422243	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911885	Замхан
280422244	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911886	Замхан
280422245	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911887	Замхан
280422246	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911888	Замхан
280422247	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911889	Замхан
280422248	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911890	Замхан
280422249	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911891	Замхан
280422250	АДУУ	ВАТЭЭЭ	ВАТЭЭЭ	Эвэн	9911892	Замхан

мэдээллийн сангаас 2004, 1995, 1975 онд төрсөн иргэдийн судалгааг авч, утсаар холбогдон хугацаандаа ирж цахим үнэмлэхээ захиалахыг сумдын бүртгэгч нар зөвлөн ажиллаж байна.

## 2. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр

Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллогыг хэлтсийн даргын тугаалын дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан тоолох үйл ажиллагааг 2021.06.10 –ны өдрөөс эхлүүлэн 14 хоногын хугацаанд зохион байгуулан ажилласан. Тооллогоор иргэний бүртгэлийн 74247 баримт, Эд хөрөнгийн бүртгэлийн /эд хөрөнгө, газар / 14507хувийн хэрэг, хуулийн этгээдийн 1301 хувийн хэрэг нийт 90055 баримт хадгалагдаж байгааг тоолон данс бүртгэлжүүлсэн.



Иргэний бүртгэлийн архивын санд орж ирж буй иргэний бүртгэлийн тоон мэдээг сар болгоны 25-ны өдрөөр тасалбар болгон мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгч байна. 2021 онд иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр 8–н төрлийн бүртгэлээс ИУБ-11 төрөлт 1327 ширхэг ,ИУБ-12үрчлэлт ,ИУБ-13 овог эцэг-эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 134 ширхэг, ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл, ИУБ-16 гэрлэлт цуцалсаны бүртгэлээс 339 ширхэг, ИУБ-18 нас баралт 297 ширхэг, аймаг нийслэлээс шилжин ирсэн маягт214 ширхэг, регистерын дугаарын өөрчлөлтийн маягт маягт-25 8 ширхэг, иргэний үнэмлэх олголт ИУБ-21 маягт 1933 ширхэг, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан ИУБ-31 2319 ширхэг, нийт 6571маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг төрөлжүүлэн ангилан хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. Иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, хууль хяналтын байгууллагуудаас ирсэн нийт 47 ширхэ галбан тоотыг хүлээн авч холбогдох нотлох маягтуудыг хуулбарлан хүргүүлэв.



Хадгалах хугацааны жагсаалтын дагуу хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу 5534 хуудас баримт бичгүүдийг нэгдүгээр улирал 2021.03.23 өдрийн 46 тоот албан бичгээр устгасан акт бичиг баримтыг үйлдэн баталгаажуулж дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу 2020-12-31 ний өдөр хүртэлх баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн 3295 хуудас баримт бичгүүдийг устгах саналыг 2021.09.23 өдөр 415 тоот албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

#### **БҮРЭН УСТГАСАН БАЙДАЛ**



#### **ДОЛОО. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2021 оны жилийн эцсийн байдлаар дараах үйлчилгээг үзүүллээ. Эд хөрөнгийн, хуулийн этгээд бүртгэлийн чиглэлээр 6240 иргэн аж ахуй нэгжид зөвлөгөө зөвлөмж өгсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд болон холбогдох тогтоол шийдвэр, журмуудын дагуу ажил үйлчилгээгээ явуулж байна. E-Mongolia, Opendata-аар дамжуулан эд хөрөнгө бүртгэлийн 325 лавлагаа иргэдэд олгосон байна.

Аймгийн 2021-2025 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2021 оны зорилтот тусгасан бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс судлан Киоск машин суурилуулах ажлыг Гэрэгэ ХХК-тай гэрээ хийж 8 сард суурьлуулснаас хойш нийт эд хөрөнгийн үйлчилгээ-49, үйлчилгээний хураамж-789566 төгрөг оруулсан байна.

Дараах сургалтуудад хамрагдсан.Үүнд:

Аймаг дүүргийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч улсын бүртгэгчийг чадавхжуулах, бүртгэл хөтлөх цахим системийн боловсруулалтанд анхаарах асуудал сэдэвт сургалт 2021.03.17

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль , Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгөх сургалт

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газартай хамтран Төрийн албаны тухай хууль, архив бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт сэдэвт арга зүйн сургалт

Аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга, албан хаагчид, Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудын дарга, ЭБАТ нарт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд зохион “Авлигын эсрэг цахим сургалт

Нийслэл, 21 аймгийн 330 сумдын төрийн албаны эмэгтэй албан хаагчид оролцоно.Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөр”-ийн цахим сургалт

Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн газрын хэлтсээс Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга,агентлагуудын хүний нөөцийн ажилтан нарт “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, төрийн албан хаагчийнхарилцаа, хандлага, ажлын үр дүнг нэмэгдүүлэх, цахим сургалт зэрэг сургалтуудад хамрагдаад байна.

Иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх үүднээс газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн материалыг сумдын бүртгэгч нараар дамжуулан хүлээн авч ажиллаж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа банк болон банк бус санхүүгийн байгууллагууд болон нотариатч нарт эд хөрөнгийн бүртгэл, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон шинэчлэгдэн гарсан хууль, журмын талаар мэдээлэл хийж гарын авлага тарааж заавар, зөвлөгөө өгсөн.

Дундын мэдээллийн сангаар дамжуулан 256 иргэн, аж ахуй нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл нийт 149 бүртгэгдсэн.

Газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлүүд:

- Худалдах гэрээ: 600
- Бэлэглэх гэрээ: 112
- Гэрээслэл, өв залгамжлах гэрээ: 87
- Арилжих гэрээ:4
- Хамтран өмчлөгч өөрчлөх:83
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх: 3
- Лавлагаа: 53
- Барьцаа гэрээ:2127
- Бүртгэлд өөрчлөлт оруулах: 218
- Үрэгдүүлсэн гэрчилгээ:23
- Барьцааны гэрээ дуусгавар болгох: 1608
- Хувийн хэрэг хаах: 8

Үйлчилгээний хураамжаас 79529219 төгрөгийн орлогыг мөн 302521290 төгрөгийн татварын орлогыг аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Нийт: 5600 мэдүүлэг хүлээн авч хувийн хэрэгт баяжилтийг хийж ажилласан. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн нэгдсэн архивт нийтдээ 14603 хувийн хэрэг хадгалагдаж байна. Сумдын бүртгэгчээр дамжуулан эд хөрөнгийн 250 бүртгэл хийсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт сар болгоны 25-ны өдөр мэдээгээ хүргүүлж байна

## НАЙМ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

### **НЭГ. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон түүнийг дагалдан гарсан журмууд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, ХЭБГ болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 245 дугаар тогтоол, Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 сарын 14-ний А/02 тоот тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”, УБЕГ-н даргын “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, индекс, код батлах тухай” 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/55 дугаар тушаал, Засгийн газрын 230 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Тус онд аж ахуйн нэгжийн улсын тооллого болсонтой холбогдуулан 2021-11-01 өдрөөс 2021-12-01 хүртэлх хугацаанд аймгийн тооллогын комиссын тусгайлсан чиг үүргийн хүрээнд хуулийн этгээдийг тооллогод бүрэн хамруулах тал дээр мэдээ Улсын бүртгэлийн хэлтсийг төлөөлөн Статистикийн хэлтэс болон Татварын хэлтэстэй хамтран ажиллаж, хуулийн этгээдийн мэдээллийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг нягтлан тулгах, шаардлагатай мэдээллийг жагсаалтаар хүргүүлэн ажиллалаа. Сүхбаатар аймгийн хэмжээгээр тооллогын ажил батлагдсан төлөвлөгөөний дагуу явагдаж, аж ахуйн нэгж байгууллагыг тооллогод заасан хугацаанд нь 100 хувь хамрууллаа.

2021 онд иргэн, хуулийн этгээдээс нийт **799** өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд **78** бүртгэгдсэнээс:

ХХК	63
Холбоо НҮТББ	5
Холбоо ҮЭБ	3
Нөхөрлөл ЗБН	2
Хоршоо	1
УТҮГ	1
ААТҮГ	1
ТБАГ	2

тус тус улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Мөн шинэчилсэн бүртгэлд Төрийн байгууллага, албан газар хэлбэртэй хуулийн этгээд **1** бүртгүүлснээр улсын бүртгэлийн мэдээллийн сан, татварын санд зөрүүтэй байсан зөрчил арилсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыгуйл ажиллагаа эрхэлдэг тухайн орон нутагт бүртгэж эхэлсэн. Үүний дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус нэгж дээр хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан цахимжуулж хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивт шилжүүлэн ажилласан байна. Үүнд: Шинээр байгуулагдсан Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл **-8**, Салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд орсон өөрчлөлт **-2** бүртгэгдсэн.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт давхардсан тоогоорнийт **210**-г бүртгэсэн байна. Үүнийг бүртгэлийн төрлөөр авч үзвэл:

Үүсгэн байгуулагч /хувьцаа эзэмшигч/-ийн өөрчлөлт - **57**

Гүйцэтгэх удирлагын өөрчлөлт **-86**

Эцсийн өмчлөгч шинээр, нөхөн, өөрчлөлт бүртгэсэн **-145**

Хариуцлагын хэлбэр өөрчилсөн **-8**,

Эрхлэх үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт – **36**

Дүрэм, гэрээ шинэчлэх – **81**,

Шилжилт хөдөлгөөн хийсэн **2**,

Гэрчилгээ дахин олгосон **31**,

Оноосон нэр өөрчлөлт **15**,

Татан буугдаж улсын бүртгэлээс хасалт хийгдсэн **2** байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн системээр иргэдийн хүсэлтээр **246** оноосон нэрийн давхардлыг шүүж, үүнээс **93** нэрийг сүлжээнд шинээр баталгаажуулж, оноосон нэрийг өөрчилсөн **15**, хугацаа сунгасан **2** баталгаажуулалт бүртгэсэн байна.

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр болон дахин нийт **106**-г олгож, **22** хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авчархивчд хүлээлгэн өгсөн.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн **21** лавлагаа олгосон байна. Үүнээс:

Хууль хяналтын байгууллагад **7**,

Иргэн, хуулийн этгээдэд **14** лавлагааг олгосон байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгийн олголтыг **228** иргэнд хийсэн байна.

Тайлангийн хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой нэхэмжлэлтэй шүүхээр хянагдаж байгаа болон Шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй хэрэг маргаан гараагүй байна.



Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтийн цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан.

#### **ХОЁР. Мэдээ, тайлангийн талаар**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS шинэ системтэй холбоотой гарсан зөрчил, алдаа дутагдлыг бүртгэл хийх явцад илрүүлэн, тухайн асуудлыг шийдвэрлэх талаарх саналыг тухай бүрт нь зургаар баталгаажуулан системийн хөгжүүлэлтийн баг болон хариуцсан улсын бүртгэгчид илгээсэн.

Хууль зүйн сайдын 2018.02.13-ны өдрийн А/24 дүгээр баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам” –ын дагуу сар бүр хуулийн этгээдийн тоон мэдээг хугацаанд нь тогтмол гаргаж ХЭБГ-т хүргүүлэн ажилласан. Мөн тоон мэдээний батлагдсан загварт тусгагддаггүй мэдээллийг оруулах тал дээр ХЭБГ-т саналаа хүргүүлсэн.

ХЭБГ-с болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, албан даалгавар, мэдээлэл судалгааг цаг тухай бүрт нь хийж хүргүүлсэн.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017.12.06-ны өдрийн А/1021 дүгээр тушаалаар баталсан “Үйлчилгээний орлогын мэдээний маягт, маягт нөхөх зааврыг батлах тухай” журмын дагуу Үйлчилгээний орлогын мэдээ болон үнэт цаасны тайланг сар бүр тогтоосон хугацаанд нь гаргаж санхүүд өгч, алдаа зөрчилгүй ажилласан.

#### **ГУРАВ. Мэдлэг чадвар, өөрийгөө хөгжүүлэх тал дээр:**

- “Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт цахим сургалтанд/2021.01.22/
- Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санаачлагаар MERIT төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “ҮР ДҮНД СУУРИЛСАН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” сэдэвт цахим сургалтанд /2021.04.05/ бүрэн хамрагдаж СЕРТИФИКАТТАЙ төгссөн.
- “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд” сэдэвт цахим сургалтанд/2021.06.17/ тус тус хамрагдаж мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн.
- “Отгонтэнгэр” Их Сургуульд Эрхзүйч мэргэжлээр 5 дахь улиралдаа суралцаад байна.

#### **ДӨРӨВ. Нийгмийн хариуцлагын хүрээнд:**

- Байгууллагын ажлын байр нүүж шинэ байранд орсонтой холбогдуулан байгууллагын тохижилтын ажилд идэвхи санаачлага гарган ажиллаж, өрөөний хаягжилтыг монгол крилл хосолсон байдлаар стандартын дагуу хийлгэж, мөн бүртгэлийн хаягууд, цонхны дугаарлалтууд, цар тахлын үеийн санамжтай наалт зэргийг хийлгэсэн.
- Архивын хувийн хэрэг нүүлгэх, цэвэрлэгээний ажлуудад хамтран оролцсон.
- Жил бүрийн мод тарих өдрөөр хамт олны хамтаар шинээр мод тарьж, өмнө нь тарьсан модны ойр орчмыг цэвэрлэсэн.

- Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, Итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан сургалт, Нэрсийн жагсаалт хэвлэх, Мэдээлэл технологийн шуурхай баг, сонгуулийн ирцийн мэдээ авах, тоног төхөөрөмж зөөж бэлтгэх зэрэг ажлуудад идэвхи санаачлагатайгаар ажилласан.
- УБЕГ-аас 81 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Монгол бичгийн “Цэвэр бичигтэн” уралдаанд идэвхитэй оролцсон.

### **ЕС. САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Тус хэлтэс нь 2021 оны 11-р сарын санхүүжилтээр улсын төсвөөс нийт 364.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарлагаар 354.7 сая төгрөгийн зардал гарч үлдэгдэл 9.3 үлдэгдэлтэй, нэмэлт санхүүжилтээр 65.2 сая төгрөгийн санхүүжилт авч 65.2 сая төгрөгийн зардал гаргаж үлдэгдэл 0 үлдэгдэлтэй хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй ил тод хүргэн ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 130.0 сая төгрөгийн орлого орж улсын төсөвт 129.0 сая төгрөгийг төвлөрүүлэн орлогын үлдэгдлээр 10.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, Үнэт цаасны тайлан , иргэний цахим үнэмлэх болон орлогын сарын мэдээг сар бүрийн эхэнд гаргаж хуулийн хугацаанд хугацаа хоцроохгүй Санхүү , аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Хүчингүй болсон үнэт цаас маягтыг бүртгэгч тус бүрээс авч жагсаалт үйлдүүлэн хүчингүй болсон шалтгааныг тодруулж хэрэв бүртгэгчийн буруугаас болсон бол төлбөрийг барагдуулан ажиллаж байна. Хүчингүй болсон үнэт цаас маягтыг жилийн эцэст нэг удаа устгалд оруулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу бүртгэлийн мэдээ мэдээлэл болон ил тод байх бүх мэдээг хуулийн хүрээнд хуулийн хугацаанд бүх мэдээлэл үнэн зөв байршуулсан болно.

Орон нутгаас албан хаагчдын тав тухтай ажиллах байрны асуудлыг шийдвэрлүүлж өрөө тасалгаануудыг тохижуулж албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн төвийн ажилчдаас хуримтлал үүсгэн хэлтсийн хэмжээнд нэмэлт орлого олох боломжийг судлан үзэж мал аж ахуйтай болох зорилт дэвшүүлэн ажиллаж эх үүсвэрийг нь тавьж ажилласан болно.

Хэлтсийн батлагдан ирсэн төсвийг үр ашигтай өр, авлага үүсгэхгүй хэлтсийн үйл ажиллагаанд зөв тооцон олон нийтэд хүртээмжтэй үр өгөөжтэй байх тал дээр анхааран ажиллаж байна.

### **АРАВ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл


хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгож, мэдээллийн технологийн төлөвлөгөө гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагчид, сумдын бүртгэгч нарын компьютер, принтер, каноны хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдалыг ханган тухай бүрт нь засаж сэлбэн, шинээр сольж ажиллаж байна. Улиралд 1 удаа хэлтсийн албан хаагчдын суурин болон зөөврийн компьютеруудын тоос тоосонцорыг цэвэрлэн ажиллаж байна. 2021 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 26 удаа засвар үйлчилгээг хийсэн. УБЕГ-аас шинээр Canon DR-M260 скайнер 2 ширхэгийг олгосон. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл” -ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг. БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сумын улсын бүртгэгч нарт компьютер 13 ширхэг, 3 үйлдэлт принтер 13 ширхэг, хурууны хээ уншигч 13 ширхэг, зургийн аппарат 13 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагаа программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцөлийн бүрдүүлэн ажиллаж байна.



Хэлтэсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сарын бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь [www.sukhbaatar.burtgel.gov.mn](http://www.sukhbaatar.burtgel.gov.mn) [www.facebook.com/suburtgel](https://www.facebook.com/suburtgel) гэсэн цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.



Тус хэлтэс нь Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын төр захиргааны байр нутгийн удирдлагын ордны 2-р байранд нүүж орсонтой холбогдуулан хэлтсийн дотоод сүлжээг Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК, интэрнэтийн сүлжээг UNIVISION LLC хамран шилэн кабель шилжээний раакуудыг шинээр зоон байршуулсан. Хэлтсийн ажилтан албан хаагчидын дотоод сүлжээ болон интернэтийн сүлжээг шинээр татан ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утасгүй эмх цэгцтэй шинээр ил гарсан утсуудыг бүрэн далдалсан. Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагааг бүрэн хэвийн ажиллаж байна.



Сумдын бүртгэгчид амаржсаны болон жирэмсэний амралт эдлэх, өндөр насны тэтгэвэрт гарах, урт хугацаагаар сургалтанд явахад тоног төхөөрөмжинд үзлэг хийж шалгаж авч, дараагийн бүртгэгчид хүлээлгэн өгч, хүлээлцсэн тухай тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд харьцаж ажиллаж байгаа албан хаагчдад ажлын хэрэгцээнд ашиглаж байгаа програм хангамжид хандан нэвтрэх нууц үгээ тодорхой хугацаанд буюу улиралд заавал сольж байх, нууц үгийн бүрдэл нь том, бага, үсэг, тоо, тусгай тэмдэгт хослуулсан байхыг зөвлөж ажиллаж байна. Мэдээлэл алдахгүй байх аюулгүй байдлыг хангах зорилгоор компьютерт гадны зөөврийн диск, флэш оруулах портуудыг хааж, зөвхөн дундаа мэдээлэл солилцохоор дотоод сүлжээний Lan messenger, 100 нэгдсэн шэйрийг ашиглаж хэвшсэн. Албан хаагчдад тог тасарсан үед тог баригчаа унтраах, ажил тарсны дараа компьютерээ бүрэн унтраах бусад тоног төхөөрөмжүүдийг зөв, зохистой хэрэглэх талаар байнга зөвлөгөө өгч ажиллаж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
УЛСЫН БҮРТГЭГЧ:...../Э.ОТГОН/

ХЯНАСАН:ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ ...../Ц.АЛТАНЦЭЦЭГ/

ТАНИЛЦСАН: ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ...../Д.БОРХҮҮ/